


# GOETHE MUSIKLABOR ULAN BATOR



GOETHE  
INSTITUT



GOETHE MUSIKLABOR  
ULAN BATOR



Гёте-Институт 2014 оноос хойш хэрэгжүүлж буй Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим төслөөрөө Монголын жазз хөгжимчдийн залуу үеийнхнийг дэмжиж байна. Төсөл хэрэгжиж эхлээд ердөө хоёрхон жилийн дараа буюу 2016 онд Монгол Улсын Консерваторит жазз хөгжмийн бакалаврын сургалт хичээллэх болсноор тус улсад жазз хөгжмийн академик боловсролын суурь тавигдсан билээ.

Энэхүү амжилтын түүх болоод түүний эздийг та бүхэнд удаах хуудсуудад танилцуулах болно. Тухайлбал, Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим (GMUB)-ын хамгийн анхны оюутны нэг Эрхэмбаярын Энхжаргал ярилцлагаараа өөрийн боловсрол, ирээдүйн төлөвлөгөө болоод жазз хөгжим түүний хувьд ямар байр суурь эзэлдэг талаар хуваалцсан юм.

Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим нь өнгөрсөн жилүүдэд Монголын жазз хөгжмийн салбарын туршлага солилцох, харилцаа холбоо тогтоох чухал төв болон хөгжжээ. Энэхүү амжилтыг ирээдүйд ч тогтвортой хадгалахад бидэнд дэмжлэг хэрэгтэй байна. Тус товхимлын сүүлийн хэсгээс та Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхимтай хамтран ажиллах боломжуудтай танилцах боломжтой.

Та бүхэн таалан болгооно уу!

Михаэль Хайнст  
Монгол дахь Гёте-Институтийн захирал



## Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим

Монгол Улс бүхий л талаараа өөрчлөгдөн хөгжиж байна. 1990 оны ардчилсан хувьсгалын дараагаас тус улс барууны соёлд үүд хаалгаа нээжээ. Хэдий өргөн хүрээнд биш боловч поп, рок, хип-хоп, жазз хөгжмийн салбарууд Улаанбаатар хотод **эрчтэй хөгжиж** байв. Ингэснээр уламжлалт боловсролын байгууллагууд энэхүү хөгжилтэй хөл нийлүүлж чадахгүйд хүрчээ.

Тиймээс Монгол дахь Гёте-Институт нь **жазз хөгжмийн залуу үеийнхэн сурч боловсроход** 2014 оноос хойш дэмжлэг үзүүлж байна.

Сонгодог болон язгуур хөгжмийн боловсрол олгогч боловсролын чухал байгууллагын нэг болох Монгол Улсын Консерваторитой хамтран Гёте-Институт нь 2014/15 оны хичээлийн жилд Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим (GMUB)-ыг үүсгэн байгуулсан юм.

Герман Улсын басс хөгжимчин Мартин Зенкерийн удирдсан GMUB төслөөр Монголд анх удаа жазз хөгжимд суралцах боломж нээгдсэн бөгөөд энэ ч цаашид өргөжин тэлсэн. Учир нь төсөл хэрэгжиж эхлээд дөнгөж хоёр жил болоход буюу 2016/17 оны



хичээлийн жилд Монгол Улсын Консерваторит **жазз хөгжмийн бакалаврын сургалт** явагдах болсон билээ.

Тусгайлан тохижуулсан хоёр анги танхимд Монголын залуу халаа болсон хөгжимчид олон хоолойн ухаан, соноршуулга, хөгжмийн түүх, хөгжимдөх урлаг зэрэгт суралцан мэргэшиж байна. Эдгээр анги танхимуудыг **өндөр чанар бүхий хөгжмийн зэмсэг**, тоног төхөөрөмжүүдээр хангасан. Нийт нэг тонн орчим эд материалыг Герман Улсаас тээвэрлэн авчирсан юм.

Хичээлийг **зочин багш** нар удирдан явуулдаг. Тэдгээр нь Германы хөгжмийн их сургуулийн багш нар болон ахисан түвшний оюутнууд байдаг бөгөөд 4-6 долоо хоногийн хугацаатайгаар Улаанбаатар хотноо хүрэлцэн ирж, Монгол Улсын Консерваторийн бакалаврын түвшний оюутнууд болон GMUB-ын хөгжимчдэд хичээл заадаг. Мөн түүнчлэн, Герман төдийгүй олон улсын уран бүтээлч, хөгжимчид цөөн хоногийн эрчимжүүлсэн сургалтыг зохион байгуулж байна.

Гёте-Институт нь жазз гармони болон жазз хөгжмийн түүх зэрэг **хөгжмийн стандарт сурах бичгийг монгол хэлнээ хөрвүүлэхэд** дэмжлэг үзүүлж, 2018 онд жазз хөгжмийн мэргэжлийн сурах бичиг анх удаа монгол уншигчдын хүртээл болсон билээ. Хамтрагчаар Монсудар хэвлэлийн газар ажилласан.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Консерватори нь Герман Улсын их сургуультай **түншлэлийн харилцаа** тогтоон ажиллахад Гёте-Институт дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгч байна. Тухайлбал, Нюрнбергийн Хөгжмийн Их

Сургууль болон Мюнхений Хөгжим Театрын Их Сургуулийн мэргэжлийн багш нар өнгөрсөн хугацаанд хүрэлцэн ирж, оюутнуудад хичээл заажээ.

2014 онд үүсгэн байгуулагдсан Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим нь Монголын жазз хөгжмийн салбар дахь **туршлага солилцох, харилцаа холбоо тогтоох төв** болон өргөжсөөр байна. Үүгээр ч зогсохгүй Монголын залуу үе халаа болсон хөгжимчдэд эх орондоо төдийгүй олон улсад академик боловсрол, мэргэжлийн зүг чигээ олох боломжийг олгож байна.

## GMUB тоон хэлээр: 2014 оноос өнөөг хүртэл

200

суралцагч

1 Тонн

хөгжмийн зэмсэг,  
тоног төхөөрөмжөөр  
хичээлийн  
анги танхимыг  
тохижуулсан

13

орны

50

зочин багш

340 тоглолт, арга  
хэмжээ

18.000

гаруй зочин

6.000

Фейсбүүк хуудасны  
дэмжигч

## GMUB-ын зочин багш нар

”

Анне  
Чиковски  
Дуулалт



“GMUB төслөөр Улаанбаатар хотод **жазз хөгжим дахин мэндэлсэн** гэж би хувьдаа үзэж байна. Оюутнууд нийслэл хотынхоо урлаг соёлын өнгө төрхийг бүрдүүлж, сурч эзэмшсэн авьяас чадвараа олон түмэнд амжилттайгаар хүргэж байна.”

Игнаси  
Терраза  
Төгөлдөр хуур



“GMUB төслийн нэгэн онцлог бол **өөр хоорондоо огт адилгүй олон соёл, жазз хэмээх хөгжмийн хэлээр хоорондоо ойлголцож** байгаад оршино!”

Пауло  
Морелло  
Гитар



“GMUB-д багшилж байх үед оюутнуудын **элэгсэг дотно зан, суралцах чин хүсэл эрмэлзэл** болон **мэргэжлийн өндөр чадвар** зэрэг нь миний сэтгэлийг ихэд догдлуулсан. Дөнгөж дөрөвхөн жилийн дотор ийм **гайхалтай жазз хөгжмийн сургалтыг** Монгол Улсын Консертаворит байгуулсан нь тун гайхамшигтай.”

Бастьен  
Рийзер  
Нарийн  
бүрээ



“GMUB-д багшлахын хамгийн сайхан нь оюутнуудтайгаа тогтоосон **нөхөрсөг харилцаа** бөгөөд бид одоо ч сайн харилцаатай байдаг. Оюутнууд маань надад Монгол орон, монгол соёлыг таниулсан. Тэдний **хөгжин дэвжиж буй энэ цаг үеийн нэг хэсэг болсондоо** маш их баяртай байна. Ингэснээрээ би өөрөө ч гэсэн ихийг сурч авсан.”

Тициан  
Йост  
Төгөлдөр хуур



“GMUB-д зөвхөн жазз төдийгүй орчин үеийн хөгжмийн бусад салбарын мэдлэг чадварыг **шинэлэг байдлаар олгож** байна. Суралцагчдын урам зориг, хүмүүсийн шинийг эрэлхийлж, сурч мэдэх гэсэн хүсэл үнэхээр гайхалтай.”

Кенни  
Вашингтон  
Дуулалт



“Хамгийн ихээр сэтгэлийг маань хөдөлгөсөн зүйл гэвэл оюутнуудтай ажиллах байлаа. Миний сонсож өссөн жазз, поп, R&B зэрэг стилийн дуу хөгжмийг тэд эзэмшин, тэдгээр олон жанрын хөгжмийг **өөрийн болгож, сэтгэлийн гүнээсээ** тоглож байсан. GMUB-ын оюутнууд бол **хөгжим бол бүх ертөнцийн хэл гэдгийн хамгийн тод жишээ юм!**”

”



Австрали  
Бразил  
Герман  
Франц  
Итали  
Япон  
Канад  
Австри  
Орос  
Шотланд  
Испани  
Өмнөд Солонгос  
АНУ

## ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхимын хичээлийг олон улсын зочин багш нар удирдан явуулдаг. 2014 оноос хойш Герман болон дэлхийн бусад 12 орны 50 гаруй зочин багш Гёте-Институтийн урилгаар Монгол Улсад ирж ажиллажээ.

## Улаанбаатар Олон Улсын Жазз Цуврал

Гёте-Институт нь JazzLab агентлагтай хамтран жазз цуврал тоглолтыг зохион байгуулж, Кенни Вашингтон, Чэмпин Фултон, Жесси Дэвис нарын дэлхийд танигдсан уран бүтээлчдийг Улаанбаатар хотноо урин авчирсан.

Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим (GMUB)-ын залуу хөгжимчид олон улсад нэр хүндтэй тэдгээр хөгжимчидтэй УДБЭТ-ын тайзнаа хамтран тоглосон билээ.

JazzLab нь Монгол улс дахь цорын ганц бөгөөд хамгийн анхны жазз хөгжмийн агентлаг юм. Тус агентлаг нь олон улсын уран бүтээлчидтэй хамтран ажиллаж, дотоодод жазз хөгжим түгээн дэлгэрэхэд дэмжлэг үзүүлдэг.



## “Жазз хөгжимгүйгээр амьдралаа төсөөлж чадашгүй нь”

Эрхэмбаярын Энхжаргал буюу Энжи 1991 онд Улаанбаатар хотноо мэндэлжээ. Тэрээр Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим (GMUB) төслийн хамгийн анхны оюутнуудын нэг бөгөөд дараах ярилцлагаар залуу уран бүтээлч маань өөрийн урлагийн гараа, зорилго болоод жазз хөгжмийн талаар хуваалцлаа!

### **Энжи, чи GMUB төслийн хамгийн анхны оюутнуудын нэг нь. Яагаад энд суралцах болсон бэ?**

GMUB-д сурах болсон маань тохиолдлын чанартай. Хөгжмийн шинэ төслийн талаар нэгэн танилаасаа дуулсан хэрэг. Тэрхүү төсөл маш онцгой санагдсан учир би ур чадварын шалгалт өгч тэнцсэн юм.

### **Дараа нь юу болсон бэ?**

Жазз хөгжмийн тал дээр харьцангуй туршлага багатай гэдгээ удалгүй ухаарсан. Өмнө нь дуу хөгжмийн багшийн чиглэлээр суралцаж төгсөхдөө монгол ардын дуун дээр түлхүү ажиллаж байсан. Гэхдээ жазз хөгжимд би шууд л дурласан гэж хэлж болно. Тэр үед Монголд жазз хөгжим цоо шинээр нэвтэрсэн тул их сонирхол татсан. Одоо бол жазз хөгжимгүйгээр амьдралаа төсөөлнө гэдэг хэцүү болжээ. Хувь тавилан маань намайг GMUB-д хөтөлсөн юм болов уу.

### **GMUB чамд хэрхэн нөлөөлсөн бэ?**

Би бусад оюутнуудын хамтаар өдөр бүр бэлтгэл хийдэг байсан. Ингэснээрээ ч ихийг сурсан. Бараг долоо хоног бүр дэлхийн өнцөг булангаас зочин багш нар ирж байлаа. Тэдний хөгжмийн зэмсэгтэйгээ хэрхэн харьцаж, хөгжмийг хэрхэн мэдэрч байгаа нь үнэхээр гайхалтай байсан. Багш нар маань надад маш их урам зориг өгч, хувь хүний хувьд ч би асар их өөрчлөгдсөн. Дуучны хувиар тайзан дээр гарах мөчийг юутай ч харьцуулшгүй. Тэр л агшинд би жинхэнэ өөрийнхөөрөө байж, эрх чөлөөг мэдэрдэг. Энэ маань Мартин багшийн л ач шүү дээ.

### **Мартин Зенкер GMUB-г үүсгэн байгуулсан. Түүний хичээлийн арга барилын онцлог юу вэ?**

Мартин хөгжимчний төдийгүй хувь хүний хувьд миний үлгэр дуурайл. Багш маань бидэнд жазз хөгжмийн онолыг заахаас гадна жазз хөгжим ямар их хүчтэйг мэдрүүлсэн.



“Хөгжмийг бүтээн гэдэг өөрт буй бүхнээ зориулах” гэж Мартин багш үргэлж хэлдэг. Тиймээс тайзан дээр гарахдаа сандралгүй, өөртөө итгэлтэй байж сурсан. Хэрвээ тэгж чадвал аливааг хийж бүтээхэд айх зүйл үгүй биз ээ. Миний бодлоор жазз хөгжмийн хамгийн сайхан нь хүн өөрийнхөөрөө байж чаддаг оршдог.

### **GMUB төсөл Монголын хөгжмийн салбарт ямар өөрчлөлт авчирсан бэ?**

Олон зүйл өөрчлөгдсөн! Жишээлбэл үзэгчид гэхэд жазз хөгжмийг чих тавин анхааралтай сонсож, бидний тоглолтод тогтмол ирж байна. Ялангуяа залуус жазз хөгжмийг улам бүр сонирхон, энэ гайхалтай хөгжим манай улсад улам хөгжиж байгаад их баяртай байна.

### **Герман Улс болоод Мюнхений Хөгжим Театрын Их Сургуульд суралцаж байгаагаасаа хуваалцана уу.**

Би үргэлж л хөл хөдөлгөөнтэй байдаг Мюнхен хотоос олон шинэ санааг олж авч байна. Бас хамт суралцаж байгаа авьяаслаг оюутан залуусаас ихийг сурч байна. Мөн Байерн мужийн соёл уламжлал, дуу хөгжим ч их сэтгэл татам юм.

**Хувь хүн:** Эрхэмбаярын Энхжаргал буюу Энжи 1991 онд Улаанбаатар хотод төрсөн. Хөгжмийн багшийн мэргэжлээр сургуулиа дүүргэсний дараа Энжи Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхим (GMUB)-д элсэн, анхны оюутнуудын нэг болжээ. Суралцаж байх хугацаандаа Монгол дахь Гёте-Институтийн хэлний сургалтад хамрагдан, Герман улсад хэд хэдэн удаа хөл тавьж, уран бүтээлээсээ сонирхуулж байв. Монгол хөг аялгууг орчин үеийн жазз элементтэй хослуулах Гончигсумлаа төслийн хүрээнд түүний анхны “Mongolian Song” цомог 2016 онд сонсогчдын хүртээл болжээ. Тэрээр өдгөө жазз дуулаач мэргэжлээр Мюнхений Хөгжим Театрын Их Сургуульд магистрын зэргийг горилон суралцаж байна.

### **Ирээдүйн зорилго чинь юу вэ?**

Миний зорилго бол мэдээж цаашид жазз дуучин болох. Гэвч миний хамгийн том хүсэл бол юу сурч мэдсэнээ Монголын жаззын шинэ үеийнхэнд түгээх юм. Ялангуяа GMUB-төслийн ачаар 2016 оноос бакалаврын түвшинд хичээллэх болсон жазз хөгжмийн оюутнуудад зааж сургахыг зорьж байна. Маш олон мэргэжлийн хөгжимчдөөр хичээл заалгачаад тэр мэдлэгийг зөвхөн өөртөө авч үлдэнэ гэвэл хувиа хичээсэн хэрэг болно шүү дээ. Тиймээс би Монголын жазз хөгжмийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж, хүмүүст хөгжмийн сайхныг мэдрүүлэхийг хүсэж байна.

### **Жазз хөгжмөөр суралцагчдад юу гэж зөвлөх вэ?**

Давтах бас өөртөө итгэх гэсэн 2 зүйлийг л захимаар байна. Жазз хөгжимчний хувьд тууштай хичээллэх маш чухал. Хэрэв хүн аливааг үнэхээр сайн хийхийг хүсвэл өдөр бүр өөрийгөө сайжруулах хэрэгтэй. Ингээд өөртөө бат итгэвэл юу ч чамайг зогсоож чадахгүй!



## ENJI: “Mongolian Song”

Тус цомог бий болсон нь Улаанбаатар дахь Гёте Хөгжмийн Танхимын үүсэл хөгжил, Барууны жазз хөгжимчид болоод Монголын авьяаслаг уран бүтээлчдийн нягт хамтын ажиллагаатай салшгүй холбоотой. Дуучин Эрхэмбаярын Энхжаргал буюу Энжи нь GMUB-ын анхны төгсөгчдийн нэг юм.

Монголын орчин цагийн сонгодог хөгжмийг үндэслэгчдийн нэг, суут хөгжмийн зохиолч Сэмбийн Гончигсумлаагаар овоглосон энэхүү төслийг Мартин Зенкер 2015 онд буюу түүний зуун насны ойгоор хэрэгжүүлсэн ба Монгол ардын хөгжмийг орчин үеийн жазз хөгжимтэй хослуулан, тус бүрийн онцлог хэв шинжийг агуулсан хөгжмийн урсгалыг бий болгохыг зорьжээ.

Сонсож тогтооход хялбар байдаг онцлогтой ардын хөгжмийн хөг аялгууг жазз хэв маягт оруулан шинээр найруулж, сонгодог хөгжимд төдийлөн танил бус хэмнэл элементийг оруулсан бөгөөд харин дуулалт илүү монгол хэв маягтай болжээ.

Хөгжмийн энэхүү хоршилд тус цомгийн өвөрмөц чанар оршиж буй агаад тус бүтээл нь олон орны хөгжимчдийн хамтын ажлын үр дүн юм.

Дуу сонсож  
үзэх:



**Холбоо барих:**

**Михаэль Хайнст**

Монгол дахь Гёте-Институтийн захирал

[michael.heinst@goethe.de](mailto:michael.heinst@goethe.de)

**Дэлгэрэнгүй мэдээлэл:**

[www.goethe.de/mongolei](http://www.goethe.de/mongolei)

[www.facebook.com/gmub.jazz](http://www.facebook.com/gmub.jazz)